



**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 25

Баянцогт

**Сум хөгжүүлэх сангийн 2017 оны  
төсөв батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8, 3.3.1, 3.5.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн 2017 оны төсвийг дараах байдлаар баталсугай.

№	Төрөл	Нийт дүн /мян.төг/
1.	<b>Орлого</b>	<b>62600.0</b>
1.1	Зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлэх хөрөнгө	50000.0
1.2	Урьд оны үлдэгдэл	12600.0
2.	<b>Зардал</b> <i>/Сангаас олгох зээлийн хүүгийн нийт 20%-ийг төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулна. /</i>	<b>748.8</b>
2.1	<b>Хяналтын үйл ажиллагааны зардал</b>	
2.1.1	Бичиг хэрэг	108.0
2.1.2	Шатахууны зардал	400.8
2.1.3	Шуудан холбоо	240.0
2.2	<b>Зээл олголт</b>	<b>61851.2</b>

2. Сум хөгжүүлэх сангаас 2017 онд олгох зээлийн дээд хэмжээг 20.000.0 мянган төгрөгөөр тогтоосугай.

3. Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга /П.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА  М.ЦОГБАЯР





СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 26

Баянцогт

Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дүгээр тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.1.1-д заасныг үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сангийн зээлийг олгохдоо дараах чиглэлийг тэргүүлэх чиглэл болгон баримталсугай. Үүнд:

- 1) ХАА-н үйлдвэрлэл, фермер
- 2) Ахуйн үйлчилгээ

2. Дээрх тэргүүлэх чиглэлийн хүрээнд төслийг сонгон шалгаруулан гэрээ байгуулан ажиллахыг орон тооны бус зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг сангийн зээл олголт, эргэн төлөлтөнд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэгт даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2014 оны 52 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 27

Баянцогт

Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.3 дахь заалтыг үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дарга:	П.Батбаатар	- Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Анхмаа	- Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ө.Амаржаргал	- Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны төлөөлөл
	М.Уянга	- Банкны төлөөлөл
	С.Мөнхцэцэг	- 1-р багийн иргэн
	Т.Үржүүл	- 2-р багийн иргэн
	Ж.Баян-Өлзий	- 3-р багийн иргэн

2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд заагдсан эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг энэхүү зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2013 оны 26 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР





СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 28

Баянцогт

Орон тооны бус ажлын хэсгийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.2 дахь заалтыг үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:


Дарга:	Ө.Жүгдэрнамжил	- ИТХ-ын тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга:	Д.Саруулбаясах	- Төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд:	Г.Цэрэндолгор	- Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны төлөөлөл
	Б.Солонго	- 1-р багийн иргэн
	Ж.Мядагмаа	- 2-р багийн иргэн
	Н.Өлзийжаргал	- 2-р багийн иргэн
	С.Буяндэлгэр	- 3-р багийн иргэн

2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд заагдсан эрх үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг энэхүү ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2014 оны 53 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг сумын Хурлын нарийн бичгийн дарга О.Мөнхцэцэгт хариуцуулсугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР